



2018 оны 04 дүгээр сарын 20  
№15/1020/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
Их Хурлын  
тогтоол**

**Бүгд Найрамдах Киргиз  
Улсад Элчин сайдын яам  
нээн ажиллуулах тухай**

**Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг**

**Дээд офицерын цол  
хураан авах тухай**

**Монгол Улсын  
Ерөнхийлөгчийн  
зарлиг**

**Журам батлах тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

152.	Бүгд Найрамдах Киргиз Улсад Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай	Дугаар 24	481
------	--	-----------	-----

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

153.	Дээд офицерын цол хураан авах тухай	Дугаар 33	482
154.	Журам батлах тухай	Дугаар 37	482

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр  
сарын 06-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар  
хот

#### **Бүгд Найрамдах Киргиз Улсад Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай**

Дипломат албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 43<sup>1</sup> дүгээр зүйлийн 43<sup>1.3</sup> дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүгд Найрамдах Киргиз Улсын нийслэл Бишкек хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулахаар тогтоосугай.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Монгол Улсын Элчин сайдын яам, Ерөнхий консулын газар, Консулын газрыг гадаадын зарим улсад нээх, сэргээн ажиллуулах тухай” Улсын Их Хурлын 2013 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 43 дугаар тогтоолын 3 дахь заалтын “хот, Бүгд Найрамдах Киргиз Улсын нийслэл Бишкек” гэснийг, мөн заалтын “тус тус” гэснийг тус тус хассугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**М.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 03 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар  
хот

### Дээд офицерын цол хураан авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Цэргийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн “Монгол Улсын харьяатаас гаргах тухай” 32 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын харьяатаас гарсан Халидалдагийн Жекейд олгосон дээд офицерын “бригадын генерал” цолыг хураан авсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2018 оны 04 дүгээр  
сарын 06-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 2, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх төрийн байгууллага хоорондын орон тооны бус байнгын ажлын хэсгийн ажиллах журам”-ыг нэгдүгээр, ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх төрийн байгууллага хоорондын орон тооны бус байнгын ажлын хэсгийн ажиллах журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулахыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга /А.Гансүх/-д үүрэг болгосугай.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 23 дугаар захирамжаар баталсан “Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах төрийн байгууллага хоорондын орон тооны бус байнгын ажлын хэсгүүдийн ажиллах журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны  
04 дүгээр сарын 06-ны өдрийн 37 дугаар  
зарлигийн нэгдүгээр хавсралт

**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ  
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН ОРОН ТООНЫ БУС  
БАЙНГЫН АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар мэдээлэл солилцох, Зөвлөлөөс гарах шийдвэрийн төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх болон гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөлдөх төрийн байгууллага хоорондын орон тооны бус байнгын ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх)-ийг Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн (цаашид “Зөвлөл” гэх) дэргэд байгуулна.

1.2. Ажлын хэсэг нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, энэхүү журмыг удирдлага болгож ажиллана.

1.3. Ажлын хэсгийг Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-18.1.9 дэх хэсгүүдэд заасан бүрэлдэхүүн хэсэг бүрээр байгуулна.

1.4. Зөвлөлийн Нарийн бичгийн дарга, ажлын албаны дарга ажлын хэсгийг нэгдсэн удирдлагаар хангаж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавина.



### **Хоёр. Ажлын хэсгийн бүтэц, бүрэлдэхүүн**

2.1. Ажлын хэсэг нь ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Зөвлөлийн ажлын албаны ахлах референт, референт, ахлах шинжээч, шинжээч, орон тооны бус шинжээч, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын төлөөллийг оролцуулна.

2.3. Зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын албаны дарга, дэд дарга, мэдээлэл, дүн шинжилгээний төвийн дарга нар ажлын хэсгийн хуралдаанд шаардлагатай тохиолдолд саналын эрхтэйгээр оролцоно.

2.4. Зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын албаны дарга, ажлын хэсгийн ахлагч нь шаардлагатай тохиолдолд тухайн салбарт мэргэшсэн, эрдэмтэн, судлаачдын санал, зөвлөгөөг авч болно.

### **Гурав. Ажлын хэсгийн үйл ажиллагааны үндсэн зарчим**

3.1. Ажлын хэсэг нь улс үндэсний язгуур ашиг сонирхлыг эрхэмлэн, бодит мэдээлэлд үндэслэсэн, харилцан уялдаатай, хууль дээдэлсэн нэгдмэл зарчим дээр тулгуурлан хамтран ажиллана.

### **Дөрөв. Ажлын хэсгийн үйл ажиллагааны зорилго**

4.1. Ажлын хэсэг нь Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан асуудлаар зөвлөлдөх зорилготой.

### **Тав. Ажлын хэсгийн чиг үүрэг**

5.1. Ажлын хэсэг нь үйл ажиллагааны зорилтоо хангахын тулд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар харилцан мэдээлэл солилцох;

5.1.2. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулж хэлэлцүүлэх асуудал, шийдвэрийн төсөл, санал, дүгнэлт боловсруулахад дэмжлэг үзүүлэх;

5.1.3. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах асуудлаар зөвлөлдөх;

5.1.4. Ажлын хэсгүүдийн хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтран ажиллах.

5.2. Ажлын хэсгийн солилцсон мэдээлэл, шийдвэрийн төсөл боловсруулахад өгсөн санал, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөлдсөн санал, дүгнэлт нь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын нэгдмэл бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, уялдуулан зохицуулах үндэслэл болно.

### **Зургаа. Ажлын хэсгийн ажиллах журам**

6.1. Ажлын хэсгийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь ажлын хэсгийн хуралдаан байна.

6.2. Ажлын хэсгийн гишүүд нь Зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын албаны даргаас өгсөн чиглэлийн дагуу сар тутам мэдээ, мэдээллийг нэгтгэж, Зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын албаны даргад танилцуулж, үүрэг чиглэл авч ажиллана.

6.3. Ажлын хэсэг нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Зөвлөлийн нарийн бичгийн дарга, ажлын албаны дарга, ажлын хэсгийн ахлагч нар шаардлагатай гэж үзвэл ээлжит бус хуралдааны товыг тогтоон, зарлан хуралдуулж болно. Хуралдааны зохион байгуулах үйл ажиллагааг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хариуцна.

6.4. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь хуралдааны товыг хүргэж, ирцийг ханган, хуралдааны тэмдэглэлийг хөтөлж, Зөвлөлийн ажлын албанд хадгалуулна. Шаардлагатай тохиолдолд хуралдааны тэмдэглэл, гарсан саналыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн, гишүүд, нарийн бичгийн даргад танилцуулна.

6.5. Ажлын хэсгийн гишүүн нь хуралдаанд өөрийн биеэр оролцоно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд тухайн асуудлыг хариуцсан өөр албан тушаалтныг томилон оролцуулна.

6.6. Шаардлагатай тохиолдолд хэд хэдэн ажлын хэсэг хамтарсан хуралдааныг зохион байгуулж болно. Хамтарсан хуралдааныг санаачилсан ажлын хэсгийн дарга уг хуралдааныг даргална.

6.7. Ажлын хэсгийн мэдээлэл, гаргасан санал нь албан ёсны бодит, баталгаатай эх сурвалжид үндэслэсэн байна.



6.8. Ажлын хэсгийн гишүүн хийсэн мэдээлэл, саналынхаа үндэслэлийг хариуцна.

6.9. Ажлын хэсэг нь олонхын саналд үндэслэн дүгнэлт гаргах бөгөөд эсрэг байр суурьтай ажлын хэсгийн гишүүний саналыг хуралдааны тэмдэглэлд тусгана. Санал тэнцсэн тохиолдолд ажлын хэсгийн ахлагчийн санал нь шийдвэрлэх санал болно.

6.10. Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж гаргасан санал, дүгнэлтийг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын эх сурвалжид ашиглаж болно.

6.11. Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан санал, холбогдох шийдвэрийн төсөл нь төрийн болон албаны нууцад хамаарна.

### **Долоо. Ажлын хэсгийн гишүүдэд хориглох зүйл**

7.1. Ажлын хэсгийн хуралдаанд оролцсон албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг бусдад задруулахыг хориглоно.

7.2. Ажлын хэсгийн хуралдааныг нээлттэй зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн цахим сүлжээгээр хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийг нийтлэхийг хориглоно.

### **Найм. Хариуцлага**

8.1. Энэхүү журмыг зөрчсөн хуулийн этгээд, албан тушаалтан, иргэнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны  
04 дүгээр сарын 06-ны өдрийн 37 дугаар  
зарлигийн хоёрдугаар хавсралт

## **ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН ОРОН ТООНЫ БУС БАЙНГЫН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

### **Нэг. Гадаад бодлогын аюулгүй байдлын ажлын хэсэг**

Ажлын хэсгийн ахлагч:

- Зөвлөлийн ажлын албаны гадаад харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан ахлах референт

Нарийн бичгийн дарга:

- Зөвлөлийн ажлын албаны батлан хамгаалах, улсын хилийн асуудал хариуцсан референт

Гишүүд:

- Зөвлөлийн ажлын албаны мэдээлэл, дүн шинжилгээний төвийн шинжээч;
- Зөвлөлийн стратеги судалгааны хүрээлэнгийн захирал;
- Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Тагнуулын ерөнхий газрын дарга;
- Гадаадын иргэн, харьяатын газрын дарга.

### **Хоёр. Мэдээллийн аюулгүй байдлын ажлын хэсэг**

Ажлын хэсгийн ахлагч:

- Зөвлөлийн ажлын албаны мэдээлэл, сүлжээний аюулгүй байдал хариуцсан ахлах референт,

Нарийн бичгийн дарга:

- Зөвлөлийн ажлын албаны мэдээлэл, сүлжээний аюулгүй байдал хариуцсан референт

Гишүүд:

- Зөвлөлийн ажлын албаны шинжлэх ухаан, мэдээллийн технологийн аюулгүй байдал хариуцсан референт;
- Зөвлөлийн ажлын албаны мэдээлэл, дүн шинжилгээний төвийн шинжээч,
- Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга;
- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын мэдээллийн технологийн хэлтсийн дарга;
- Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга;
- Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга;
- “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал,
- Тагнуулын ерөнхий газрын төрийн болон онц чухал мэдээллийн сүлжээ, харилцаа холбооны аюулгүй байдлыг хангах, цахим аюул, заналтай тэмцэх чиг үүрэг бүхий газрын дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын эрүүгийн цагдаагийн албаны дарга;





- Зэвсэгт хүчний жанжин штабын холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан эрх бүхий албан тушаалтан.

### **Гурав. Мэргэжлийн хяналтын аюулгүй байдлын ажлын хэсэг**

Ажлын хэсгийн ахлагч:

- Зөвлөлийн ажлын албаны хүн ам, эрүүл мэнд, удмын сангийн аюулгүй байдал хариуцсан ахлах референт

Нарийн бичгийн дарга:

- Зөвлөлийн ажлын албаны хүн ам, эрүүл мэнд, удмын сангийн аюулгүй байдал хариуцсан референт

Гишүүд:

- Зөвлөлийн ажлын албаны мэдээлэл, дүн шинжилгээний төвийн шинжээч;
- Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга;
- Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга;
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга;
- Гаалийн ерөнхий газрын дарга;
- Стандарт, хэмжил зүйн газрын дарга;
- Үндэсний аудитын газрын дарга.

### **Дөрөв. Тусгай албадын аюулгүй байдлын ажлын хэсэг**

Ажлын хэсгийн ахлагч:

- Зөвлөлийн ажлын албаны дотоод аюулгүй байдал хариуцсан ахлах референт

Нарийн бичгийн дарга:

- Зөвлөлийн ажлын албаны төрийн байгуулалт, тусгай албад хариуцсан референт

Гишүүд:

- Зөвлөлийн ажлын албаны иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал хариуцсан ахлах референт;
- Зөвлөлийн ажлын албаны улс төрийн болон иргэний нийгмийн байгууллага хариуцсан референт;

- Зөвлөлийн ажлын албаны мэдээлэл, дүн шинжилгээний төвийн шинжээч;
- Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Тагнуулын ерөнхий газрын дэд дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга;
- Авлигатай тэмцэх газрын дэд дарга;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга.

### **Тав. Цэргийн бодлогын аюулгүй байдлын ажлын хэсэг**

Ажлын хэсгийн ахлагч:

- Зөвлөлийн ажлын албаны гадаад бодлого, оршин тогтнохуйн аюулгүй байдал хариуцсан ахлах референт

Нарийн бичгийн дарга:

- Зөвлөлийн ажлын албаны батлан хамгаалах, улсын хилийн асуудал хариуцсан референт

Гишүүд:

- Ерөнхийлөгчийн тамгын газрын цэргийн бодлогын асуудал хариуцсан ахлах референт;
- Зөвлөлийн ажлын албаны мэдээлэл, дүн шинжилгээний төвийн шинжээч;
- Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Зэвсэгт хүчний жанжин штабын дарга;
- Тагнуулын ерөнхий газрын дарга;
- Хил хамгаалах ерөнхий газрын дарга;
- Онцгой байдлын ерөнхий газрын дарга;
- Дотоодын цэргийн штабын дарга.

### **Зургаа. Шашны асуудлын аюулгүй байдлын ажлын хэсэг**

Ажлын хэсгийн ахлагч:

- Зөвлөлийн ажлын албаны Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, боловсрол, шашин хариуцсан ахлах референт

Нарийн бичгийн дарга:

- Зөвлөлийн ажлын албаны Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, боловсрол, шашин хариуцсан референт

**Гишүүд:**

- Зөвлөлийн ажлын албаны мэдээлэл, дүн шинжилгээний төвийн шинжээч;
- Хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Соёл, урлагийн газрын дарга;
- Тагнуулын ерөнхий газрын дэд дарга;
- Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга.

**Долоо. Эдийн засгийн аюулгүй байдлын ажлын хэсэг****Ажлын хэсгийн ахлагч:**

- Зөвлөлийн ажлын албаны эдийн засаг, дэд бүтэц, эрдэс баялагийн асуудал хариуцсан ахлах референт

**Нарийн бичгийн дарга:**

- Зөвлөлийн ажлын албаны эрчим хүчний асуудал хариуцсан референт

**Гишүүд:**

- Зөвлөлийн ажлын албаны мэдээлэл, дүн шинжилгээний төвийн ахлах шинжээч;
- Зөвлөлийн мэдээлэл, дүн шинжилгээний төвийн банк, санхүүгийн асуудал хариуцсан шинжээч;
- Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Ашигт малтмал, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Татварын ерөнхий газрын дарга;

- Тагнуулын ерөнхий газрын дарга;
- Монгол банкны Дэд ерөнхийлөгч;
- Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга;
- Үндэсний статистикийн хорооны дарга;
- Гаалийн ерөнхий газрын дэд дарга.

### **Найм. Экологийн аюулгүй байдлын ажлын хэсэг**

Ажлын хэсгийн ахлагч:

- Зөвлөлийн ажлын албаны байгаль, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал хариуцсан ахлах референт

Нарийн бичгийн дарга:

- Зөвлөлийн ажлын албаны байгаль, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал хариуцсан референт

Гишүүд:

- Зөвлөлийн ажлын албаны мэдээлэл, дүн шинжилгээний төвийн шинжээч;
- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга.

### **Ес. Хүнсний аюулгүй байдлын ажлын хэсэг**

Ажлын хэсгийн ахлагч:

- Зөвлөлийн ажлын албаны хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал хариуцсан ахлах референт

Нарийн бичгийн дарга:

- Зөвлөлийн ажлын албаны хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал хариуцсан референт

Гишүүд:

- Зөвлөлийн ажлын албаны мэдээлэл, дүн шинжилгээний төвийн шинжээч;



- Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн нарийн бичгийн дарга;
- Мал эмнэлэг, үржлийн газрын дарга;
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга.

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

**Индекс: 200003**